



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 22 өдөр

Дугаар А/168

Улаанбаатар хот

Өсвөрийн шатрын аварга шалгаруулах
“Их нүүдэл” тэмцээнд оролцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн нэрэмжит Өсвөрийн шатарчдын аварга шалгаруулах “Их нүүдэл” тэмцээний 2 дугаар шатны тэмцээнд шалгарсан сурагчдыг 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдөр 3 дугаар шатны тэмцээнд бэлтгэн оролцуулсугай.

2. Тэмцээнд оролцуулахад шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3. Шаардагдах 791,200 (Долоон зуун ерэн нэгэн мянга хоёр зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.


4. Сурагчдын бэлтгэлийг сайтар хангуулан зохион байгуулалтын өндөр түвшинд чанар, үр дүнтэй оролцуулахыг “Хангай” сургууль (Э.Соёмбобат)-д, захирамжийн биелэлтэд хяналт тавьж, ажиллахыг Нийгмийн хөгжлийн хэлтэс (Б.Цогжавхлан)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 10 сарын 22 ны өдрийн 418 дугаар
захирамжийн хавсралт



“ИХ НҮҮДЭЛ” ШАТАРЧДЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНД
ОРОЛЦОХОД ЗАРЦУУЛАГДАХ ТӨСӨВ

Д/Д	Төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүр зардал	Нийт зардал
1	Шатахуун	л	80	3,390	271,200
2	Өдрийн хоол	ш	26	20,000	520,000
	Нийт				791,200